



**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2022 оны 05 сарын 02 өдөр

Дугаар 8/29

Ховд


**Дүгэржавын Эрдэнэбатыг ажилд түр томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.4, 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 50 дугаар зүйлийн 50.1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ажлын зайлшгүй шаардлагаар аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Барилга, дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний асуудал хариуцсан гэрээт ажилтнаар Дүгэржавын Эрдэнэбатыг 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн тухайн ажлын байрны сул орон тоог Төрийн албаны тухай хууль, тогтоомжийн хүрээнд нөхөх хүртэл хугацаанд түр томилсугай.

2. Д.Эрдэнэбаттай хөдөлмөрийн гэрээ байгуулж Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээ"-ний ТЗ-5-1 дэх шатлал буюу 642,388 төгрөг (зургаан зуун дөчин хоёр мянга гурван зуун наян найм)-өөр цалинжуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, аж ахуйн тасгийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч (Б.Нямдэлгэр)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.ЭНХБОЛД

8400 03 0443